



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2025. 01. 08 № 1/23

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн тайланг хүргүүлэв.

Хавсралт хуудастай.



Г.ЧИНБАТ

8200051618



ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ : www.gov-altai.gov.mn

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ : info@govi-altai.gov.mn

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ : 7048-4042 ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ : (976) 70484042

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ : 82093



ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ

ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠰᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠪᠠ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ ᠤᠳᠢᠷᠳᠠᠭᠠᠨ
ᠵᠥᠪᠯᠡᠯᠢᠨ ᠬᠣᠷᠯᠠᠨ
ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠯ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 09.

Есөнбулаг

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлд:

“Найм. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2024 оны жилийн эцсийн тайланг хэлэлцүүлэх тухай асуудлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Я.Жаргалцэцэг танилцууллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ 8:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 24 агентлаг, 18 сумын нийт 901 өргөдөл, гомдлыг 91 хувьтай шийдвэрлэн ажилласан байна. Хурлаас дараах үүрэг, чиглэлийг хүргүүлэв. Үүнд:

1.Тайлан мэдээг Засгийн газрын тогтоолд заасан хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх;

2.Өргөдөл гомдлыг богино хугацаанд шийдвэрлэх, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл гомдол гаргахгүй байх;

3.Орон нутгийн онцлог байдал, цаг үе, улирлын чанартай холбогдон байнга давтагдан ирдэг өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж цаашид дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах;

4.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг олон нийтэд тогтмол сурталчилж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Я.Жаргалцэцэгт даалгав” гэжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗАРТ 2024 ОНД
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ТҮҮВЭРЧИЛСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.01.09

Алтай хот

Хяналт-шинжилгээний зорилго: Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд түүвэрчилсэн хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээний арга зүй: Хяналт-шинжилгээг 2024 онд аймгийн Засаг даргын Тамгын газарт Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах - 1111 төвөөс шилжиж ирсэн болон аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт ирсэн өргөдөл, гомдолд үндэслэн гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээний ерөнхий мэдээлэл: 2024 онд Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах - 1111 төвөөс 67 өргөдөл шилжиж ирсэн, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт ирсэн 271 өргөдөл, гомдол бүртгэгдсэн байна.

Хяналт-шинжилгээний үр дүн: Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах - 1111 төвөөс шилжин ирсэн 67 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийлээ. Шийдвэрлэлт 94.03 хувьтай байна. Үр дүнгийн товчоог танилцуулбал:

Нийт өргөдөл, гомдлын тоо	67
Бүрэн шийдвэрлэж хариу өгсөн	63
Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа	4

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт 271 өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Эдгээр 271 өргөдлийн 12.2 хувь буюу 33 өргөдөл нь аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын байгууллагын даргад хандаж гаргасан цалинтай, цалингүй чөлөө хүсэх, хөдөлмөрийн дотоод журмын дагуу дэмжлэг, туслалцаа хүсэх, ажлаас чөлөөлөгдөх, ажилд орох, сэлгэн шилжиж ажиллах тухай зэрэг дотоод үйл ажиллагаатай холбоотой байна. Дотоод үйл ажиллагаатай холбоотой өргөдлүүд 100.0 хувь буюу бүрэн шийдвэрлэгдсэн байна.

Дотоод үйл ажиллагаатай холбоотой өргөдлөөс бусад аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт ирсэн 238 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ хийлээ. Шийдвэрлэлт 96.6 хувьтай байна. Үр дүнгийн товчоог танилцуулбал:

Нийт өргөдөл, гомдлын тоо	238
Бүрэн шийдвэрлэж хариу өгсөн	208
Хариу өгсөн боловч шийдвэрлэгдээгүй	22
Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа	8

ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1.Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах - 1111 төвөөс шилжин ирсэн 67 өргөдөл, гомдлын 94.03 хувийг бүрэн шийдвэрлэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад шийдвэрлэлтийн дундаж хугацаа 15 хоног болж, буурсан үзүүлэлттэй байна.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод үйл ажиллагаатай холбоотой 33 өргөдөл, гомдлыг 100 хувь буюу бүрэн шийдвэрлэсэн байна.

3.Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт ирүүлсэн 271 өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 91.0 хувьтай байна. Орон сууцны дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан 7, эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн 9, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээний зардалд дэмжлэг хүссэн 6, нийт 22 өргөдөлд хуулийн хугацаанд хариу өгсөн боловч төсөв, санхүүгийн хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалан санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай дээрх өргөдлүүд иргэний хүсэлтийг бүрэн хангаж шийдвэрлэгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт 2024 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1.Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт шийдвэрлэлтийн байдлыг тодорхой бичиж, холбогдох шийдвэрүүд, албан бичгийг хавсаргаж байх;

2.Хугацаа болоогүй, хүлээгдэж байгаа өргөдлүүдийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2024 ОНЫ ТАЙЛАН

2025.01.03

Алтай хот

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын 2024 оны 4 дүгээр улирлын тайланг Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах -1111 төвөөс шилжин ирсэн болон аймгийн 18 сум, 24 агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээг нэгтгэн дүгнэлээ.

Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авахтай холбоотой хүсэлтийг хасаж, бусад асуудлаар 592 хүсэлт, төрийн байгууллагын албан хаагчид хүргүүлсэн талархал 4, нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх чиглэлээр болон, хүнсний аюулгүй байдал, бараа бүтээгдэхүүний чанар, стандарт, хугацаанд хяналт тогтмол хийх тухай ирүүлсэн 68 санал, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан 237 гомдлыг хүлээн авч ажиллалаа.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагууд болон сумдаас нийт 901 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 819 буюу 91%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 82 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Төрийн албан хаагчийн ур чадвар, ёс зүй, төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой 19 өргөдөл, буюу 13%-ийг эзлэж байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 43 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр аймгийн нийт төрийн байгууллагуудын 480 гаруй албан хаагчтай уулзалт хийж Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, хуулийн хэрэгжилт, орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах, мөн төрийн албаны шинэтгэл, Ёс зүйн тухай хуулийн талаар уулзалт, сургалтыг зохион байгууллаа. Төрийн албаны, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудаар 12 байгууллага, 6 сумын 636 төрийн албан хаагчдад сургалтыг хийж, мэдээллээр ханган ажиллалаа.

Мөн байгууллагын ажилтан албан хаагчдад 2024 онд дагаж мөрдөх шинээр батлагдсан хууль тогтоомжууд болон Галт зэвсгийн тухай хууль, Ногоон бүс төсөл арга хэмжээ, Шинэ Үндсэн хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, “Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал” Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, “Хүний эрх ба үндсэн хууль”, Архи түүний хор уршиг, Орон нутаг дахь хүний эрх ба анхаарах асуудал, Хууль зүйн туслалцааны тухай, Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Хүний эрхийн ойлголт”, зэрэг сэдвийн хүрээнд танхимын сургалтыг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүртээмж, чанар стандарт холбоотой 5% хувь буюу 6 гомдол байна. 2024 оны 2 сарын 28-нд “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага”, “Сувилагчийн ёс зүйн хэм хэмжээ”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хэм хэмжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 86 эрүүл мэндийн ажилтан албан хаагч хамрагдлаа.

Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх, цахим үндэстэн арга хэмжээг эрчимжүүлэх, иргэдийн цахим гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Цахимд хэвшье” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд төрийн болон, хувийн хэвшлийн байгууллагын удирдлагууд, албан хаагч, иргэд, аж ахуй нэгжийн төлөөлөл хамрагдаж цахим хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар сургалт мэдээлэл хийж зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ. Нутгийн удирдлагын ордонд ХУРДАН КИОСК машиныг байршуулж иргэд төрийн байгууллагын үйлчилгээг нэг дороос цаг алдалгүй авах боломжтой боллоо.

Мөн Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв, төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хамтарсан “Цахимд зөв байя” аяны хүрээнд Говь-Алтай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс Цагдаагийн газар, Прокурорын газар, Тагнуулын газартай хамтран Кибер аюулгүй байдлын талаар багц сургалт хийж, 130 оюутан, 250 сурагч, 300 гаруй Төрийн албан хаагч, 80 гаруй иргэд хамрагдлаа. Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд И-Монголиа нэгдсэн системээс 10,480 иргэнд “ХУРДАН” цэгээр дамжуулан операторын горимоор төрийн цахим үйлчилгээг хүргэж байна.

Хот тохижилт, амьдрах орчинтой холбоотой 23 өргөдөл буюу 16%-ийг эзлэж байна. Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн

А/244 тоот захирамжаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт зудын улмаас үхэж хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн арга хэмжээнд, хамгийн их малын хорогдолтой Дэлгэр, Чандмана, Бигэр, Халиун сумдад малын сэг, зэмийн устгалын үйл ажиллагааг орон нутгийн төр, захиргааны байгууллага, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүн хүч, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 оны 6 сард Мөнх-Инспайринг ХХК нийлүүлсэн 160 сая төгрөгний үнэтэй хог татагч тусгай зориулалтын 1 автомашиныг хүлээн авснаар, хог тээврийн зориулалтын автомашин техникийн хүчин чадал нэмэгдэн ажиллаж байна.

Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн и-баримт олголт болон баталгаажуулалттай холбоотой 35% хувь буюу 52 гомдол ирүүлсэн байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар нэгдсэн удирдамжийн дагуу ажил зохион байгуулж, зах худалдааны төвийн хамтран ажиллах гэрээнд өөрчлөлт оруулж, худалдаа үйлчилгээ эрхлэгч хүн бүрт зөвлөгөө өгч, Татварын хэлтсийн цахим хуудсаар дамжуулан цахим сургалт сурталчилгааг түгээн, гомдлын холбогдогч бүрт нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Хандив тусламж дэмжлэг хүссэн 160 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, сургалтын төлбөр, тэмцээн уралдаанд оролцох замын зардал, эмчилгээний төлбөрт нийт 139,070 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ТАНИЛЦСАН

ХЯНАСАН

Ш.ЭРДЭНЭБАТ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН

Я.ЖАРГАЛЦЭЦЭГ

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Т.ЭРДЭНЭСҮРЭН

Говь-Алтай аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл,гомдлын
төрөл, хүлээн авсан байдал / өссөн дүнгээр/

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл					Хүлээн авсан хэлбэр			
	Талархал	Хүсэлт	Гомдол	Санал	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2	3	4	5	6	7	8	9
Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар	4	592	237	68	544	94	77	77	109





Говь-Алтай аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл,гомдлын шийдвэрлэлтийн байдал / өссөн дүнгээр/

Шийдвэрлэлтийн байдал								
Шийдвэрлэж харчу өгсөн			Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо				
Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо	63	0	3	0	82	1		
438	53	153	108					



Говь-Алтай аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн гомдлын агуулга, өргөдөл гомдлыг бууруулах арга хэмжээний санал /өссөн дүнгээр/

№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн И-баримт олголт болон баталгаажуулалттай холбоотой	52	35%	Гомдлын холбогдогч бүрт нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлэх.
2	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой.	29	20%	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой өргөдлийн дийлэнх хувийг 1995-2000 оны хоорондох хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй өргөдөл гомдол эзэлдэг. Үүнтэй холбоотой даатгуулагчдад мэдээлэл хүргэх
3	Хүүхдийн эрхийн зөрчил болон мөнгөн тэтгэмжтэй холбоотой	25	17%	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.
4	Хот тохижилт, халаалт амьдрах орчинтой холбоотой	23	16%	Хог хаягдлын хураамжийн тухай журмыг хэм хэмжээний актаар бүртгүүлэх, машин техникийн парк шинэчлэл хийх, нохой устгалыг тогтмол хийж зардлыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт жил бүр тусгах.
5	Төрийн албан хаагчийн ур чадвар, ёс зүйтэй холбоотой	19	13%	Аймгийн нийт төрийн байгууллагын албан хаагчдад 2024 онд шинээр мөрдөгдөж байгаа болон нэмэлт өөрчлөлт орсон хуулиудаар сургалт зохион байгуулан ажиллах. Сургалтын төлөвлөгөөнд харилцаа хандлага, ёс зүйн талаар сургалтыг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажиллах, сахилга хариуцлагыг сайжруулах
НИЙТ ДҮН		148	100%	